



**МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр,  
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41  
И-мэйл: moh@moh.gov.mn, http://www.moh.gov.mn

2023. 12. 07 № 3/5577  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН ДАРГА,  
ЗАХИРАЛ НАРТ**

Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хорооноос ирүүлсэн “Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний ачааллыг бууруулах талаар” 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 02 дугаар зөвлөмжийг үүгээр хүргүүлж байна.

Хавсралт: 6 хуудастай.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
ГАЗРЫН ДАРГА *S. Erdentuya* С.ЭРДЭНЭТУЯА



**145??7318**



**НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТЫН  
АВТО ЗАМЫН ТҮГЖРЭЛИЙГ  
БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРОО**

14201 Улаанбаатар хот, Төрийн ордон,  
Сүхбаатарын талбай,  
Утас: 26 36 45,  
Цахим шуудан: [info@tcrcc.gov.mn](mailto:info@tcrcc.gov.mn)

2023. 12. 04 № 01/681  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Зөвлөмж хүргүүлэх тухай**

Монгол улсын Засгийн газрын 341 дүгээр тогтоолоор батлагдсан “Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хороо”-ны дүрмийн 3.1.5 дахь заалтыг үндэслэн, “Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хороо”-ны ээлжит V дугаар хуралдаанаар хэлэлцэж, шийдвэрлэсний дагуу Нийслэл Улаанбаатар хотын авто замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулахад иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын оролцоог хангах зөвлөмжийг хүргүүлж байна.

Төрийн захиргааны байгууллагууд харьяа нэгж, салбар байгууллагууддаа зөвлөмжийг хүргүүлэн хэрэгжүүлэх, үр дүнг олон нийтэд сурталчлан мэдээлэх, тайлан мэдээг сар бүр Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хороонд цахимаар ([info@tcrcc.gov.mn](mailto:info@tcrcc.gov.mn)) болон албан бичгээр ирүүлж ажиллана уу.

МОНГОЛ УЛСЫН САЙД, НИЙСЛЭЛ  
УЛААНБААТАР ХОТЫН АВТО ЗАМЫН  
ТҮГЖРЭЛИЙГ БУУРУУЛАХ  
ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА



Б.ДЭЛГЭРСАЙХАН



## НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТЫН АВТО ЗАМЫН ТҮГЖРЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ЗӨВЛӨМЖ

2023 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

### Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний ачааллыг бууруулах талаар

Үндэсний хорооны 2023 оны ээлжит V хуралдаанаар Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, тулгамдаж буй асуудлуудыг хэлэлцээд нийтийн тээврийн парк шинэчлэлттэй холбогдуулан автобусны чиглэлийн давхцалыг арилгах, нэгж хугацаанд нэг зогсоолд нэг автобус ирж, чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээг чөлөөлөх байдлаар төлөвлөлтийг хийх, авто зогсоолын ашиглалтыг сайжруулахад анхаарах шаардлагатай гэж дүгнэлээ.

Иймд замын хөдөлгөөний эрчмийг нэмэгдүүлэх, түгжрэл бууруулах, нийтийн тээврийн хүртээмж, авто зогсоолын хүрэлцээг нэмэгдүүлэх зорилгоор дараах чиглэлээр ЗӨВЛӨМЖ хүргүүлж байна.

### НЭГ. НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР

#### 1.1. Нийслэлийн Нийтийн тээврийн газарт:

1.1.1. Нийтийн тээврийн дахин төлөвлөлтийн дагуу нийтийн тээврийн автобуснуудыг дараах үндсэн чиглэлүүдэд 2024 оны 01 дүгээр сарын 01 ний өдрөөс эхлэн зорчуулж эхлүүлэх;

Чиглэл-1; Энхтайваны өргөн чөлөөний М:1 "5шар-Офицеруудын ордон" чиглэлд 2 минутын интервалтай зорчиход шаардлагатай нийт 55 автобус, ачааллын бус 21:00 цагаас хойш 4 минутын интервалтай зорчиход шаардлагатай 27 автобус тус бүрийн ашиглалтын бэлэн байдлыг хангуулж;

Чиглэл-2; Шар хадны эцсээс Доржийн гудамж, Сансарын аюулгүйн тойрог, Их тойруугийн гудамж, Ард Аюушийн өргөн чөлөөгөөр зорчих М:2 "Шар хадны эцэс-3,4 дүгээр хорооллын эцэс" хүртэл чиглэлд 2 минутын интервалтай зорчиход шаардлагатай 52 автобус, ачааллын бус 21:00 цагаас хойш 4 минутын интервалтай зорчих 26 автобус тус бүрийн бэлэн байдлыг хангуулах;

Чиглэл-3; Зунжингаас Нисэх чиглэлд Чингэлтэйн өргөн чөлөө, Алтайн гудамж, Их сургуулийн гудамж, Сүхбаатарын гудамжаар зорчин Чингисийн өргөн чөлөө, Наадамчдын авто зам, Нисэхийн аюулгүйн тойрог хүртэл зорчих М:3 буюу "Зунжин-Нисэх" чиглэлд 2 минутын интервалтай зорчиход шаардлагатай 95 автобус, ачааллын бус 21:00 цагаас хойш 4 минутын интервалтай зорчих 48 автобус тус бүрийн бэлэн байдлыг хангуулж, маршрут чиглэлд нарийвчилсан тооцоолол хийх;

Дээрх төлөвлөлтийн дагуу М:1, М:2, М:3 чиглэлүүдэд зорчих тээврийн хэрэгслийн ашиглалтын бэлэн байдлыг хангуулах;

1.1.2. Ботаникийн эцсээс Цагдаагийн академийн өргөн чөлөө, Чулуун овооны аюулгүйн тойргоос Нарны замаар Гермес худалдааны төв хүртэлх М:4 чиглэлд 2 минутын интервалтай зорчиход шаардлагатай 77 автобус, ачааллын бус 21:00 цагаас хойш 4 минутын интервалтай зорчих 39 автобусны бэлэн байдлыг хангуулах;

Шинэ 100 айл худалдааны төвөөс Хүннүгийн гудамж, Махатма Гандийн гудамж, Дунд голын гудамж, Үйлдвэрийн гудамжаар ТЭЦ-3 хүртэлх авто замын чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээг чөлөөлөн, өглөө оройны зорчигч урсгал ачаалалтай цагаар автобусны хүлээгдлийн хугацааг 2 минут, ачааллын бус 21:00 цагаас хойш 4 минут байхаар тооцож төлөвлөлтийг боловсруулах;

М:1, М:2, М:3 чиглэлүүдийн төлөвлөлт бүрэн хэрэгжиж, эерэг үр дүн гарсан тохиолдолд 2024 оны 2 дугаар улиралд багтаан М:4, М:5 чиглэлийн авто замуудад чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээг чөлөөлөх эсэх талаар зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллах;

1.1.3. Цаашид тойрог зам болон туслах чиглэл, богино эргэлтийн чиглэлүүдийг дахин төлөвлөлтийн хавсралт схемийн дагуу зохион байгуулан хэрэгжүүлэх;

1.1.4. Нийтийн тээврийн жолооч нарын ур чадварыг нэмэгдүүлэх, харилцааны зөв хандлагыг төлөвшүүлэх, үйлчилгээний соёлд суралцуулах сургалтыг тогтмол үр дүнтэй зохион байгуулах. (Жолооч зогсоолын эгнээнд цагийн хуваарь, дарааллын дагуу зөв зогсдог болох, ажлын байранд хувцаслалт, биеэ авч явах байдал, ёс зүйтэй харилцааг эрхэмлэх);

1.1.5. Зорчигчид автобусны орц гарцаар цуварч орж гарч сурах, бусад зорчигчдод саад болохгүй байх зөв хандлагад төлөвших, замын хөдөлгөөнд оролцогч бусад жолооч нар нийтийн тээврийн хэрэгсэлд зам тавьж өгч сурах талаар ёс зүйн сургалт мэдээллийг олон нийтэд сурталчлах;

## 1.2. Цагдаагийн Ерөнхий газар, Тээврийн цагдаагийн албанд:

1.2.1. Чиглэлийн тээврийн хэрэгслийн 1-р эгнээг чөлөөлж байгаатай холбогдуулан Замын хөдөлгөөний дүрмийн 11.5 заалтыг зөрчсөн аливаа тээврийн хэрэгслийг зогсоон шалгаж, шийдвэрлэн, хөдөлгөөнийг чөлөөтэй явуулах чиглэлээр ажиллах бүх хүн хүч, техник хэрэгсэлийнхээ төлөвлөлтийг 12 дугаар сарын 10-ны дотор боловсруулан танилцуулж, 12 дугаар сарын 15 ний өдрөөс эхлэн олон нийтэд сурталчилан таниулах;

1.2.2. Уулзварыг бүрэн гүйцэд нэвтрэн гарах боломжийг хязгаарласан түгжрэл, саатал бий болсон үед чиглэлийн тээврийн хэрэгслийг хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулсаны үндсэн дээр бусад тээврийн хэрэгсэлд саад болохгүйгээр уулзвар нэвтрүүлэх байдлаар зохицуулалт хийх;

1.2.3. Чиглэлийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд саад учруулсан тээврийн хэрэгслийг нэн даруй зорчих хэсгээс чөлөөлж, шалгаж шийдвэрлэх;

1.2.4. Бусад тээврийн хэрэгслийн жолооч нарт чиглэлийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд саад учруулахгүйгээр хөдөлгөөнд оролцох талаархи сургалт, мэдээллийг жолооны сургалтын төвүүдээр дамжуулан өгөх ажлыг зохион байгуулж, дадал хэвшилд сургах;

1.2.5. Замын хөдөлгөөнд оролцогчдыг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, тогтоомжийн дагуу хөдөлгөөнд соёлтой боловсон оролцох талаар үе шаттай сургалт, сурталчилгаа зохион байгуулах;

1.2.6. Нийслэлийн 6 дүүргийн нутаг дэвсгэрт Замын хөдөлгөөний түгжрэл үүсгэж буй зөрчлийн талаар арилжааны ТВ, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглан тогтсон өдөр, цагт мэдээлэл хийгдэхээр төлөвлөгдөж байгаа тул эфирийн мэдээлэл хэлэлцүүлэгт хамтран ажиллах алба хаагчдыг бэлтгэж өгөх ажлыг хэвшүүлэхэд анхаарч ажиллах;

### 1.3. Нийслэлийн Замын хөгжлийн газарт:

1.3.1. Нийтийн тээврийн чиглэлийг дахин төлөвлөж байгаатай холбогдуулан Энхтайваны өргөн чөлөө, Чингэлтэйн өргөн чөлөө, Чингисийн өргөн чөлөө, Ард Аюушийн өргөн чөлөө, Их тойруугийн гудамж, Наадамчдын зам, Хүннүгийн гудамж, Нарны зам, Цагдаагийн академийн өргөн чөлөө зэрэг авто замуудын чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээг бүрэн чөлөөлөх ажлын хүрээнд дээрх 5 чиглэл тус бүрийн автобусны буудлуудын байршлыг тодорхойлох;

Авто замын дагуух төлөвлөсөн маршрут:1 хавсралт зургийн дагуу 2024 оны 01 дүгээр сарын 01 ний өдрөөс эхлэн чиглэлийн тээврийн хэрэгсэл зорчих бэлтгэл ажлыг хангах;

Зорчих хэсгийн дагуу байрласан авто зогсоолуудыг хааж, бүтээн байгуулалтын улирал эхлэх үед ногоон байгууламж, явган болон дугуйн зам болгон тохижуулах;

1.3.2. Дээрх 5 гол гудамж, зам дагуу байрласан чиглэлийн тээврийн хэрэгслийн 224 замналын зогсоолын талбайг үндсэн эгнээнээс тусгаарлахгүйгээр шийдэх, хүйтний улиралд түр хаалт, хашилгаар зохицуулах;

1.3.3. Замын хөдөлгөөний дүрэмд заасаны дагуу чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээг чөлөөлөхтэй холбогдуулан 2 метр тутамд цацруулагч бүхий товрууг (катафот) байрлуулах. (Товрууны загвар болон байршуулах зааврыг хавсралтад тусгав);

1.3.4. Нарантуул ОУХТ, Дүнжингарав, Мишээл экспо, Зунжин, Хархорин, Номин агуулах, гэх мэт боломжтой байршлуудыг 22:00 цагаас 06:00 цаг хүртэлх буюу үйлчилгээний бусад цагаар нийтийн тээврийн зогсоол (авто парк) хэлбэрээр ашиглах боломжийг бүрдүүлэх.

### 1.4. Замын хөдөлгөөний удирдлагын төвд:

1.4.1. Дээрх төлөвлөлттэй уялдуулан чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээнд 200 метр тутамд зөрчил илрүүлэх камерын хяналт тогтоож, чиглэл тус бүрээр хяналтыг цахимжуулах нөхцлийг бүрдүүлж, дэд бүтцийг шийдвэрлүүлэх;

1.4.2. Гэрлэн дохионы шилжилт, горимыг чиглэлийн тээврийн хэрэгсэл буудал хооронд 2 минут тутамд чөлөөтэй саадгүй зорчих төлөвлөлттэй уялдуулан өөрчлөлт зохицуулалт хийх;

## **ХОЁР. ЗОГСООЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР**

### 2.1. Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд:

2.1.1. Зогсоолын бүртгэл, төлбөрийн нэгдсэн ухаалаг системийг 2024 оны 01 дүгээр сарын 01 ний өдрөөс эхлэн RFID технологид суурилсан зам, тээврийн нэгдсэн системийн ерөнхий төлөвлөлтөд тусгаж, төрийн үйлчилгээний нэгдсэн системтэй холбох;

2.1.2. Тээврийн хэрэгслийн эзэмшигч, жолооч нарт торгууль, төлбөр, татвар, хураамжийн нэхэмжлэхийг үүссэн өдрөөс хойш 48 цаг тутмын давтамжтайгаар сануулдаг байх;

2.1.3. Тээврийн хэрэгслийн цахим гэрчилгээнд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тээврийн хэрэгсэл” гэсэн үзүүлэлт оруулж, таних нөхцлийг бүрдүүлэх;

### 2.2. Цагдаагийн Ерөнхий газар, Тээврийн цагдаагийн албанд:

2.2.1. Бусад тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд саад учруулсан тээврийн хэрэгслийг ачиж журамлах Замын хөдөлгөөний дүрмийн түр ба удаан зогсох журмын хэрэгжилтийг хангах нөхцлийг бүрдүүлэх;

2.3. Нийслэлийн замын хөгжлийн газарт:

2.3.1. Нийтийн эзэмшлийн төлбөртэй зогсоол талбайг тохижуулж, тоног төхөөрөмж суурилуулах, цахимжуулах ажлыг зохион байгуулах;

2.3.2. Нийтийн эзэмшлийн төлбөртэй зогсоолыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлж, иргэний хяналтын тогтолцоог хангах;

2.3.3. “Нийслэл Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт тээврийн хэрэгслийн зогсоол ашигласны төлбөр авах үйл ажиллагааны журам”-д төлбөр авах, төлбөрийг хуваарилах;

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний асран хамгаалагчийн автомашины төлбөрөөс хөнгөлөх боломжийн талаар нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулж, шийдвэрлүүлэх;

2.3.4. Иргэд нийслэлийн захын хэсэгт автомашинаа үлдээн, нийтийн тээврээр зорчих боломжийг олгох бага төлбөртэй (цагт 500-1000 төг гм) зогсоол ажиллуулах, цаашид дээрхи зорилгоор их багтаамжийн авто зогсоолыг нэмж байгуулах талаар судалж, шийдвэрлүүлэх;

2.3.5. Төрийн байгууллагын гаднах нийтийн эзэмшлийн зогсоол, талбайг нийтэд үйлчлэх төлбөртэй үйлчилгээний хэлбэрээр ашиглах, түүнийг ажиллуулах эрхийг хувийн хэвшил, ТББ-д гэрээгээр өгч, зогсоолын үйл ажиллагаанд тавих иргэдийн хяналт, төлбөрийн системийн тогтолцоог зохицуулах талаар арга хэмжээ авах;

2.3.6. Зогсоол ашигласан төлбөрийн хэмжээг хотын А бүсэд цагт 5000 төгрөг, Б бүсэд цагт 4000 төгрөг, бусад байршлуудад цагт 3000 төгрөг байхаар “Нийслэлийн нутаг дэвсгэрт авто зогсоол ашигласаны төлбөрийн хувь хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолыг Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар шийдвэрлүүлэх.

2.4. Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийн бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжид:

2.4.1. Нийслэл Улаанбаатар хотын авто зогсоолын стратеги, менежментийг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлж буй төслүүдийг нэгтгэж, нэгдсэн удирдлагаар хангах, Үндэсний хорооны шийдвэртэй уялдуулах.

## **ГУРАВ. АЧААНЫ АВТОМАШИНЫ ХӨДӨЛГӨӨНИЙГ ЗОХИЦУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР**

3.1. Нийслэлийн нийтийн тээврийн газарт:

3.1.1. Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2014 оны 102 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн гудамж, замын хөдөлгөөнд ачааны автомашиныг цагийн хязгаарлалтай оролцуулах түр зөвшөөрөл олгох журам”-ыг хүчингүй болгож бизнес эрхлэгчдийг учруулах хүндрэлээс чөлөөлөх;

Ачааны автомашинаар бизнес эрхлэгчид зөвхөн ачааллын бус цагаар буюу өглөө 10:00-17:00 цагт, орой 21:00-06:00 цагийн хооронд хөдөлгөөнд оролцож байхаар:

Хөдөлгөөний оргил цагууд болох өглөө 06:00-10:00, 17:00-21:00 цагуудад хөдөлгөөнд огт оролцуулахгүй байхаар зохицуулах;

Энэ зохицуулалт хүргэлтийн бусад бага оврын тээврийн хэрэгсэл, мопед, унадаг дугуйн хөдөлгөөнд хамаарахгүй;

Эдгээр зохицуулалтыг Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх.

3.1.2. Хөдөлгөөнд оролцогч тусгай зориулалтын миксер, том оврын ачааны машин, ковш, зэрэг зам талбай бохирдуулах эрсдэлтэй автомашинуудын хөдөлгөөний хяналтыг хийж, зөрчил гарсан тохиолдолд хохиролыг арилгуулах талаар зохицуулалт хийх;

3.1.3. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний болон жолоочийн үүрэг хариуцлага, зөрчлийн мэдээллийг хэрэглэгчид цахим мэдээллийн системийг ашиглан мэдээлж байх. (Автомашин ачилт, торгууль, татварын нэхэмжлэх, төлөлт, замын хураамж, санамж, зөрчил гм);

Дээрх зөвлөмжийн хэрэгжилтийн талаархи тайланг болон дараагийн долоо хоног хийгдэх ажлын төлөвлөгөөг долоо хоног бүрийн даваа гаригийн 12:00 цагаас өмнө Үндэсний хорооны ажлын албанд цахимаар ирүүлж хэвших.

Email: info@tcrcc.gov.mn



Монгол улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга

Б. ДЭЛГЭРСАЙХАН

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар захирагч, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны Нарийн бичгийн дарга

Х. НЯМБААТАР